
МОНГОЛЫН АРХЕОЛОГИЙН ӨВ

ARCHAEOLOGICAL RELICS OF MONGOLIA

-XII-

МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛ



THE SMALL MONUMENTS OF MONGOLIAN RUNIC INSCRIPTION

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
СОЁЛЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛЫН АРХЕОЛОГИЙН ӨВ

ARCHAEOLOGICAL RELICS OF MONGOLIA

ЕРӨНХИЙ РЕДАКТОР | EDITOR-IN-CHIEF

Г.ЭРЭГЗЭН | EREGZEN G.
С.ЧУЛУУН | CHULUUN S.

Улаанбаатар | Ulaanbaatar
2020

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН БАТАЛСНААР СОЁЛЫН ЯАМНЫ ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР ХЭВЛЭВ.

PRINTING APPROVED BY THE SCIENTIFIC COUNCIL OF INSTITUTE OF ARCHAEOLOGY, MONGOLIAN ACADEMY OF SCIENCES.
PUBLISHED UNDER THE AUSPICES OF THE MONGOLIAN MINISTRY OF CULTURE

МОНГОЛЫН АРХЕОЛОГИЙН ӨВ

ARCHAEOLOGICAL RELICS OF MONGOLIA

ЕРӨНХИЙ РЕДАКТОР
Гэлэгдоржийн ЭРЭГЗЭН
Сампилдондовын ЧУЛУУН

БОТИЙН РЕДАКТОР
Б.АЗЗАЯА, Н.ГЭРЭЛМАА

EDITOR-IN-CHIEF
Gelegdorj EREGZEN
Sampildondov CHULUUN

VOLUME EDITORS
AZZAYA B., GERELMAA N.

I БОТЬ.	VOL. 1.
МОНГОЛЫН ЧУЛУУН ЗЭВСЭГ	**STONE TOOLS OF MONGOLIA**
Б.ЦОГТБААТАР	TSOGTBAATAR B.
II БОТЬ	VOL. 2
МОНГОЛЫН БУГАН ХӨШӨӨ	**DEER STONES OF MONGOLIA**
Ц.ТӨРБАТ	TURBAT TS.
III БОТЬ	VOL. 3
МОНГОЛЫН ЭРТНИЙ БУЛШ ОРШУУЛГА	**ANCIENT FUNERAL MONUMENTS OF MONGOLIA**
Г.ЭРЭГЗЭН	EREGZEN G.
IV БОТЬ	VOL. 4
МОНГОЛЫН ХАДНЫ ЗУРАГ	**ROCK ART OF MONGOLIA**
Н.БАТБОЛД	BATBOLD N.
V БОТЬ	VOL. 5
МОНГОЛЫН ХҮН ЧУЛУУ	**STONE STATUES OF MONGOLIA**
Ч.АМАРТҮВШИН, Б.БАДМА-ОЮУ	AMARTUVSHIN CH. , BADMA-OYU B.
VI БОТЬ	VOL. 6
МОНГОЛЫН ЭРТНИЙ ШАВАР САВ	**ANCIENT CERAMIC POTTERIES OF MONGOLIA**
Ц.ТӨРБАТ	TURBAT TS.
VII БОТЬ	VOL. 7
ЭРТНИЙ НҮҮДЭЛЧДИЙН УРЛАГИЙН ДУРСГАЛ	**CULTURAL MONUMENTS OF ANCIENT NOMADS**
А.ОЧИР, Л.ЭРДЭНЭБОЛД	OCHIR A., ERDENEBOLD L.
VIII БОТЬ	VOL. 8
МОНГОЛ БА БҮС НУТГИЙН БУГАН ХӨШӨӨНИЙ СОЁЛ	**DEER STONES CULTURE OF MONGOLIA AND NEIGHBORING REGIONS**
Ц.ТӨРБАТ	TURBAT TS.
IX БОТЬ	VOL. 9
МОНГОЛ БА БҮС НУТГИЙН БУГАН ХӨШӨӨНИЙ СОЁЛ	**DEER STONES CULTURE OF MONGOLIA AND NEIGHBORING REGIONS**
Ц.ТӨРБАТ	TURBAT TS.
X БОТЬ	VOL. 10
МОНГОЛЫН ЭРТНИЙ ХОТ СУУРИН	**ANCIENT SETTLEMENTS OF MONGOLIA**
Д.ЦЭВЭЭНДОРЖ	TSEVEENDORJ D.



МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛ

THE SMALL MONUMENTS OF MONGOLIAN RUNIC INSCRIPTION

The Recent Study on the Small Monuments of Mongolian Runic Inscriptions

XII БОТЬ

Улаанбаатар | Ulaanbaatar
2020

ННА 80
ДАА 400
Б-341

МОНГОЛЫН АРХЕОЛОГИЙН ӨВ
ЦУВРАЛ ЗУРАГТ ЦОМОГ

ARCHAEOLOGICAL RELICS OF MONGOLIA
CATALOGUE SERIES

МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛ

- XII БОТЬ -

БОТИЙН РЕДАКТОР
Б.АЗЗАЯА, Н.ГЭРЭЛМАА

THE SMALL MONUMENTS OF MONGOLIAN RUNIC INSCRIPTION

- VOLUME 12 -

VOLUME EDITORS
AZZAYA B., GERELMAA N.

ЗОХИОГЧ | AUTHOR
Ц.БАТТУЛГА | BATTULGA TS.

ХЭВЛЭЛИЙН ЭХ, ДИЗАЙН | LAYOUT DESIGN
Б.Баясгалан | Bayasgalan B.

МОНГОЛЫН РУНИ БИЧГИЙН БАГА ДУРСГАЛ
The Small Monuments of Mongolian Runic Inscription


Хэвлэлийн хуудас: х.х 45.5
Цаасны хэмжээ: 280 x 210 / A4
Хэвлэсэн тоо: 300 ш

Pages: 45.5
Paper size: 280 x 210 / A4
Printed copies: 300

ISBN: 978-9919-20-873-8

© Энэхүү ном зохиогчийн эрхийн хуулийн дагуу хамгаалагдсан тул зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дахин хэвлэх, цахим хэлбэрээр болон хэвлэмэл байдлаар хэсэгчлэн хуулбарлах, хувилан олшруулахыг хориглоно.

© All rights reserved. No part of this publication may be reproduced, distributed, or transmitted in any form or by any means, including photocopying, or other electronic or mechanical methods, without the prior written permission of the publisher.



Баян-Өлгий аймаг. Цэнгэл сум.
Сүүн голын эх.
Süün gol. Tsengel soum. Bayat-Ölgii aimag.

МЭНДЧИЛГЭЭ
GREETINGS



Монголын түүхч, археологич эрдэмтдийн судалгааны үр дүнг олон нийтэд ойлгомжтой байдлаар таниулах, археологийн өв болсон дурсгал, олдворуудыг сурталчлах зорилгоор миний бие санаачлан эхлүүлсэн "Монголын археологийн өв" цувралын удаах боть хэвлэгдэх болсонд баяртай байна.

Цувралын XII боть "Монголын руни бичгийн бага дурсгал" бүтээлд 18 аймгийн нутгаас илэрсэн 159 дурсгалын гэрэл зураг, хэв дардас, уншлага тайлбар болон судалгааны тойм зэрэг өргөн агуулгатай мэдээлэл багтжээ. Анх удаа Монголын руни бичгийн бага дурсгалыг нэгтгэн хэвлүүлж буй нь бүтээлийн онцлогийг тодорхойлох бөгөөд Түрэг судлалд чухал ач холбогдолтой эрдэм шинжилгээний хэрэглэгдэхүүн болно гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсын Соёлын яамнаас түүх соёлын өвийн хадгалалт хамгаалалт, судалгаа, сурталчилгааг хөгжүүлэх явдлыг онцгой анхаарч буй. Соёлын өв нь аливаа улсын өмнөх түүхийн бодит гэрч төдийгүй ирээдүйг харах чиг хандлагыг тодорхойлогч билээ. Соёлын яамнаас цаашид мэргэжлийн судлаач эрдэмтдийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, гүнзгийрүүлэх, бүртгэн баримтжуулах, хамгаалах, сурталчлах ажилд тасралтгүй дэмжлэг үзүүлж ажиллах юм.

Монголын Соёлын өвийг хадгалж хамгаалах, сурталчлан таниулах үйлс өргөжин хөгжихийн ерөөл өргөе.

Монгол Улсын Засгийн Газрын гишүүн,
Соёлын Сайд **С.ЧУЛУУН**

I am grateful that the subsequent volume of the "Archaeological Relics of Mongolia" series, which initiated by me, to present the results of the research by Mongolian historians and archaeologists with the aim of giving a better understanding of monuments and artifacts which are archaeological relics to the audiences .

"Small Monuments of Mongolian Runic Inscription", Vol. 12, contains a wide range of information, including photographs, rubbings, prints, readings, and survey reviews of 159 monuments from 18 provinces. It is the first time this catalogue "Small Monuments of Mongolian Runic Inscription" has been published and it will be a significant source for Turkic studies.

The Ministry of Culture of Mongolia is paying special attention to the preservation, protection, research, and development of historical and cultural heritages. Cultural heritage is not only a true witness to a country's past history but also a determinant of its vision for the future. The Ministry of Culture will continue to support the expansion, deepening, documentation, protection, and promotion of research by the scholars and researchers.

I wish that the preservation and promotion of Mongolia's cultural heritage to expand.

Member of the Government of Mongolia,
Minister of Culture **S. CHULUUN**

ӨМНӨХ ҮГ
FOREWORD

"Монголын археологийн өв" цувралын XII боть болох "Монголын руни бичгийн бага дурсгал" бүтээл хэвлэгдэж буйд баяртай байна. Манай хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлж ирсэн тус цуврал нь Монголын археологийн дурсгал, олдворын талаар олон нийтэд цэгцтэй ойлголт өгөх, судалгаа шинжилгээний ололт амжилтыг сурталчлан таниулах зорилготой билээ.

Монгол орон археологийн дурсгалаар нэн баялаг, түүний дотор эртний бичиг үсгийн дурсгал ч цөөнгүй бий. XIX зууны төгсгөлөөс гадаадын эрдэмтэн судлаачид анхааран судлах болсноор Хөшөө Цайдам, Хар балгас, Тоньюкукын гэрэлт хөшөө зэрэг өргөн агуулгатай бичээсийн дурсгалууд дэлхийд алдаршижээ. Эртний Түрэг, Уйгурын бичээсүүд Орхоны хөндий, Енисей мөрний сав газруудаас илэрч байсан тул анхандаа "Орхон-Енисейн бичиг" хэмээн нэрлэсэн ч эрдэм шинжилгээний ном бүтээлд "руни бичиг" гэдгээр нэрлэж нэгэнт хэвшжээ.

1894 онд академич В.Радловын бүтээл хэвлэгдсэнээс хойш 100 гаруй жилийн хугацаанд манай улсын нутгаас 200 шахам руни бичгийн дурсгал илэрч судалгааны эргэлтэнд орсон байна. Эдгээрийн дотор дээр өгүүлсэн өргөн агуулга, түүх хүүрнэх их бичээс бүхий алдарт гэрэлт хөшөөнүүдээс гадна цөөн үгтэй бага бичээсүүд дийлэнхийг эзлэх юм. Одоогоор Монгол Улсын нутгаас ийм бага бичээс бүхий руни бичгийн 159 дурсгал илэрч судлагдсан байна.

"Монголын руни бичгийн бага дурсгал" бүтээлд 18 аймгийн нутагт бүртгэгдсэн бага бичээсүүдийг бүгдийг хамруулснаар онцлог бөгөөд бичээсийн гэрэл зураг, хэв дардас, уншлагаас гадна байршил, илрүүлж судалсан байдал, одоо хадгалагдаж буй газар зэрэг холбогдох мэдээллийг багтаасан нь эрдэм шинжилгээний үнэтэй хэрэглэгдэхүүн болжээ. Бага бичээсийн дурсгалыг илрүүлсэн судлаачид бичээсийн агуулгыг товч тайлбарлах байдлаар нийтлүүлсэн нь олон. Харин ийм байдлаар нэгтгэж, системтэйгээр танилцуулсан нь үгүй тул уг бүтээл Монголын төдийгүй дэлхийн Түрэг судлалд чухал ач холбогдолтой, үнэтэй сурвалж болно гэдэгт итгэлтэй байна.

Эцэст нь руни бичгийн дурсгалуудыг биеэр үзэж, гэрэл зургаар баримтжуулан, хэв дардсыг авч, уншиж тайлах судалгааг гардан хийсэн номын зохиогч доктор Ц.Баттулга, бүтээлийг шүүн ариутгасан доктор Б.Аззаяа, Н.Гэрэлмаа нарт эрдмийн амжилт хүсье.

Номыг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн Соёлын яам, Сайд академич С.Чулуун болон дэмжиж тусалсан хүмүүс, хэвлэлийн эх бэлтгэлийг хариуцсан дизайнер Б.Баясгалан, үнэтэй санал зөвлөгөө өгсөн редакцийн зөвлөлийн гишүүдэд талархал илэрхийлж байна.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал,
доктор **Г.ЭРЭГЗЭН**

Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences is pleased to announce the publication of "Small Monuments of Mongolian Runic Inscription" in the catalogue series of "Archaeological Relics of Mongolia" as Volume 12. The goal of this series, published by our institute, is to provide the audiences with a better understanding of Mongolian archaeological monuments and artifacts and promote research achievements.

Mongolia is rich in archaeological monuments, including numerous ancient monuments with inscriptions. Since the end of the 19th century, foreign scholars have been paying particular attention to the studies of inscriptions of the Khushoo Tsaidam Monument, Khar Balgas Monument and Tunyukuk Monument and they became well-known in the world. Ancient Turkic and Uighur scripts found in the Orkhon Valley and the Yenisei River basin, thus firstly they were called the Orkhon-Yenisei script, but are now known as "Runic scripts" in the scientific works.

Since the publication of academician W.Radlov's work in 1894, almost 200 runic inscriptions have been discovered in Mongolia and studied scientifically. Besides the famous monuments with complete runic inscriptions as historical source material mentioned above, most of them have inscriptions with few words. So far, 159 runic inscriptions with such small inscriptions have been found and studied in Mongolia.

"Small Monuments of Mongolian Runic Inscription" is unique that includes all the inscriptions registered in 18 aimags. In addition, each inscription contains information such as study reviews, readings, photographs, rubbings, printed or drew copies and current locations are which makes it valuable scientific source. Scholars who discovered the small inscriptions have published a brief description of the contents of them. Since it has not been compiled and presented systematically before, this work will be a significant and valuable source not only for Mongolian Turkic studies but also for Turkic studies in the world.

Finally, I would like to wish success to Professor Ts. Battulga, an author of the book, who conducted research on runic inscriptions, photographed, imprinted and deciphered. I wish to thank B.Azzaya, PhD and N.Gerelmaa, PhD for their careful editing.

Also, I would like to express my sincerest gratitude to the Ministry of Culture and Minister Academician S.Chuluun for their support in publishing the book, B.Bayasgalan, a designer, and members of the editorial board for their valuable advice.

DR. G.EREGZEN,

Director of the Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences

- ГАРЧИГ -

УДИРТГАЛ 16

АРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 24

Ажираг, Тууланын бичээс 28
Бага Хайрханы бичээс 30
Билгэ хааны тахилын онгоны зэл (балбал) чулууны бичээс 34
Көлтигиний гэрэлт хөшөөний мэлхий чулуун суурь дээрх бичээс 36
Тариатын гэрэлт хөшөөний мэлхий чулуун суурь дээрх бичээс 37
Их Хануй нуурын бичээс 38
Нумын ясан наалт дээрх бичээс 44
Тайхир чулууны бичээс. 45
Шавар тоосго дээрх бичээс. 53
Хиргисийн хоолойн дээврийн нөмрөг ваар дээрх бичээс 54
Чөдрийн ясан чагт дээрх бичээс 55

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 56

Бага Ойгурын бичээс. 59
Зүрх уулын бичээс 66
Зүүн оройн бичээс 70
Өртөөн булагийн бичээс 75
Тэхтийн бичээс. 78
Хар Магнайн бичээс 80
Шивээт Хайрханы бичээс. 82
Эрээн харганатын бичээс. 88

БАЯНХОНГОР АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 92

Асгатын бичээс. 96
Бөмбөгөрийн бичээс 100
Гурван Мандалын бичээс. 106
Далтын бичээс 112
Олон нуурын бичээс 114
Соёо Хүрэнгийн бичээс. 116
Замын бууц (Улаан Цохиот)-ын бичээс 118
Хавцгайтын Хавцлын бичээс 122
Ханангийн бууцны бичээс 126
Хиргисийн овооны бичээс 127
Цохиотын бичээс. 132

БУЛГАН АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 138

"Алтан хүн (браектет)"-ий бичээс. 141
Арханангийн бичээс 142
Гурвалжин уулын бичээс 144

Их Асгат (Хөл Асгат)-ын бичээс. 148
Хангидай хадны бичээс. 154

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 160
Алтан хадны бичээс 164
Бигэрийн бичээс 172
Бугатын бичээс 182
Давиртын бууцны бичээс. 186
Хөшөөт толгойн бичээс 188
Хулсана Амны бичээс. 190
Шаахар толгойн бичээс 191

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 194
Чойрын хүн чулууны бичээс 197

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 198
Их Нартын бичээс 200

ДОРНОД АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ. 204
Зоосны бичээс 207

ДУНДГОВЬ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 208
Дэл уулын бичээс 211
Дэрст Хөтөлийн бичээс. 223
Жиримтийн бичээс. 224
Их Бичигтийн бичээс. 230
Тамганы бичээс 233
Ханангийн бууцны бичээс 234

ЗАВХАН АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 236
Зүрийн овооны бичээс 239
Цэцүүхийн бичээс 242

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 246
Өвөрхангайн бичээс 249
Тавьтын бичээс 250
Тэгшийн Хүрэн (Тэвш)-ийн бичээс 254
Хутаг уулын бичээс 256

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ 262
Байшинтын Харын бичээс 265
Далан уулын бичээс 268

Их Өлзийт уулын бичээс . . . 269
Сэврэйн бичээс . . . 272
Уртын голын бичээс . . . 273
Хотгорын бичээс . . . 276

СҮХБААТАР АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ . . . 278
Донгойн Ширээн цогцолборын хөшөөдийн бичээс . . . 281

ТӨВ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ . . . 284
Мөнгөн савны бичээс. . . . 287
Налайхын бичээс. . . . 288
Мөнгөн аяганы бичээс . . . 289
Туньюкукийн тахилын шаазасны бичээс . . . 290
Улаанчулуутын бичээс . . . 291

УВС АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ . . . 298
Долоогойдойн гэрэлт хөшөөний бичээсөө . . . 301
Төмөр цоргын бичээс. . . . 304
Шанаган хэв (Ачит нуур)-ийн бичээс . . . 305

ХОВД АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ . . . 310
Бийрэгийн бичээс . . . 313
Дарвийн бичээс . . . 316
Өвөр дөрөлжийн бичээс . . . 322
Тариатын өвөлжөөний бичээс . . . 323
Хөгжим дээрх бичээс. . . . 324
Ямаан усны бичээс. . . . 328

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ . . . 338
Ивдэйн голын бичээс. . . . 341
Орук хадны бичээс. . . . 342

ХЭНТИЙ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ . . . 348
Рашаан хадны бичээс . . . 351
Цэнхэр Мандалын бичээс. . . . 352

ХОЛБОГДОХ НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ . . . 354

- CONTENTS -

INTRODUCTION 16

THE RUNIC INSCRIPTIONS IN ARKHANGAI AIMAG 24

The Ajirag and Tuulant Inscription 28

The Baga Khairkhan Inscriptions 30

The Inscription on the Balbal of the Bilge Khagan Memorial Complex 34

The Inscription on the Tortoise-figured Socle of the Kültigin Monument 36

The Inscription on the Tortoise-figured Socle of the Tariat Monument 37

The Ikh Khanui Nuur Inscription 38

The Inscription on the Bone Plate for Reinforcing Bow 44

The Taikhir Chuluu Inscriptions 45

The Inscription on the Clay Brick 53

The Inscription on the Roof Tile found in Khirgisiin Khooloi 54

The Inscription on the Bone Toggle of a Hobble 55

THE RUNIC INSCRIPTIONS IN BAYAN-ÖLGII AIMAG 56

The Baga Oigur Inscriptions 59

The Zürkh Uul Inscription 66

The Züün Oroi Inscription 70

The Örtöön Bulag Inscription 75

The Tekht Inscription 78

The Khar Magnai Inscription 80

The Shiveet Khairkhan Inscriptions 82

The Ereen Kharganat Stele 88

THE RUNIC INSCRIPTIONS IN BAYANKHONGOR AIMAG 92

The Asgat Inscription 96

The Bömbögör Inscription 100

The Gurvan Mandal Inscriptions 106

The Dalt Inscription 112

The Olon Nuur Inscription 114

The Soyo Khüren Inscription 116

The Zamiin Buuts (Ulaan Tsokhiot) Inscription 118

The Khavtsgaitiin Khavtsal Inscription 122

The Khanangiin Buuts Inscription 126

The Khirgisiin Ovoo Stele 127

The Tsokhiot Inscriptions 132

THE RUNIC INSCRIPTIONS IN BULGAN AIMAG 138

The Inscription of 'Golden Man' 141

The Arkhanan Inscription 142

The Gurvaljin Uul Inscription 144

The Ikh Asgat (Khöl Asgat) Inscriptions . . . 148
The Khangidai Inscription . . . 154

THE RUNIC INSCRIPTIONS IN GOVI-ALTAI AIMAG . . . 160
The Altan Khad Inscriptions . . . 164
The Biger Inscriptions . . . 172
The Bugat Inscription . . . 182
The Davirtiin Buuts Inscription . . . 186
The Köshööt Tolgoi Inscription . . . 188
The Khulsana Am Inscription . . . 190
The Shaakhar Tolgoi Inscriptions . . . 191

THE RUNIC INSCRIPTIONS IN GOVISÜMBER AIMAG . . . 194
The Inscription on the Stone Statue found in Choir . . . 197

THE RUNIC INSCRIPTIONS IN DORNOGOVI AIMAG . . . 198
The Ikh Nart Inscription . . . 200

THE RUNIC INSCRIPTIONS IN DORNOD AIMAG . . . 204
The Inscription on the Coin . . . 207

THE RUNIC INSCRIPTIONS IN DUNDGOVI AIMAG . . . 208
The Del Uul Inscriptions . . . 211
The Derst Khötöl Inscription . . . 223
The Jirimt Inscriptions . . . 224
The Ikh Bichigt Inscription . . . 230
The Inscription of the Stamp . . . 233
The Khanangiin Buuts Inscription . . . 234

THE RUNIC INSCRIPTIONS IN ZAVKHAN AIMAG . . . 236
The Züriin Ovoo Inscription . . . 239
The Tsetsüükh Inscription . . . 242

THE RUNIC INSCRIPTIONS IN ÖVÖRKHANGAI AIMAG . . . 246
The Övörkhangai Inscription . . . 249
The Tavit Inscription . . . 250
The Tegshiin Khüren (Tevsh) Inscription . . . 254
The Khutag Uul Inscription . . . 256

THE RUNIC INSCRIPTIONS IN ÖMNÖGOVI AIMAG . . . 262
The Baishintiin Khar Inscription . . . 265
The Dalan Uul Inscription . . . 268

The Ikh Ölziit Uul Inscription 269
The Sevrei Inscription 272
The Urtiin Gol Inscription 273
The Khotgor Inscription 276

THE RUNIC INSCRIPTIONS IN SÜKHBAATAR AIMAG 278
The Steles of Dongoin Shiree Complex 281

THE RUNIC INSCRIPTIONS IN TÖV AIMAG 284
The Inscription on the Silver Vessel 287
The Nalaikh Inscription 288
The Inscription on the Silver Cup 289
The Inscription on the Clay Piece of Tunyukuk Offering Site 290
The Ulaanchuluut Inscriptions 291

THE RUNIC INSCRIPTIONS IN UVS AIMAG 298
The Doloogoidoi Stele 301
The Tömör Tsorgo Inscription 304
The Shanagan Khev (Achit Nuur) Inscriptions 305

THE RUNIC INSCRIPTIONS IN KHOVD AIMAG 310
The Biireg Inscription 313
The Darvi Inscriptions 316
The Övör Dörölj Inscription 322
The Tariatiin Övöljöö Inscription 323
The Inscription on the Musical Instrument 324
The Yamaan Us Inscriptions 328

THE RUNIC INSCRIPTIONS IN KHÖVSGÖL AIMAG 338
The Ivdein Gol Inscription 341
The Oruk Khad Inscriptions 342

THE RUNIC INSCRIPTIONS IN KHENTII AIMAG 348
The Rashaan Khad Inscription 351
The Tsenkhermandal Inscription 352

BIBLIOGRAPHY 354

УДИРТГАЛ

Монгол орон эртний бичиг соёлын өлгий нутаг билээ. Тиймээс ч манай улсын нутаг дэвсгэрээс брахми, согд, руни, уйгур, хятан, зөрчин, монгол, нангиад, сири, араб, перс, төвд, санскрит, дөрвөлжин, тод, манж, ланз, соёмбо, вагиндра зэрэг хорь гаруй үсэг бичгийн олон арван дурсгал илэрч түүх, хэл соёлын судлалд чухал сурвалж, эх хэрэглэгдэхүүн болсоор байна.

Үсэг бичгийн үнэ цэнэтэй тэдгээр дурсгалуудаас руни бичгийн сурвалжууд олдож илэрсэн тоо, төрөл, сэдэв агуулгаараа ихээхэн ялгаатай билээ.

Монголын руни бичгийн дурсгалын судалгаа анх 1889 онд Н.М.Ядринцев (1842-1894)-ийн удирдсан Оросын Газарзүйн Нийгэмлэгийн Дорнод Сибирийн салбарын шинжилгээний анги ирж Орхоны хөндий дэх руни бичгийн томоохон дурсгалуудыг илрүүлж дэлхий дахинд мэдээлснээр(Ядринцев Н.М. 1892b, 1892a, 1901) эхэлсэн түүхтэй. Энэхүү нээлт, мэдээллийн мөрөөр Фин-Угорын нийгэмлэгээс А.Хейкел (Axel Olai Heikel, 1851-1924)-ээр удирдуулсан шинжилгээний анги 1890 онд (Heikel A. 1892), Оросын Шинжлэх Ухааны Академиас В.Радлов (Wilhelm Radloff, 1837-1918)-оор удирдуулсан судалгааны тусгай анги 1891 онд (Радлов В.В. 1892) тус тус ирж үл тайлагдах бичээсийн эх хэрэглэгдэхүүн цуглуулсан бөгөөд улмаар тайлан судлах их үйлс дэлхий дахинд өрнөсөн ажээ.

Нууц тайлагдашгүй хэмээн нэрлэж байсан уг бичгийн дурсгалыг Данийн хэлбичгийн их эрдэмтэн В.Томсен 1893 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 38 үсэгтэй авианы бичгээр бичсэн болохыг тогтоосон нээлтээ мэдээлсэн ажээ (Thomsen V. 1894).

В.Радлов 1891 онд Монгол оронд ирж цуглуулсан эх хэрэглэгдэхүүн, өөрийн тогтоосон

INTRODUCTION

Mongolia is the birthplace of ancient literature and culture. Therefore, dozens of ancient Brahmi, Sogdian, Runic, Uighur, Chinese, Jurchen, Mongolian, Chinese, Syrian, Arabic, Persian, Tibetan, Sanskrit, 'Phags-pa, Clear Script, Manchu, Rañjanā script (Lantsa), Soyombo, and Vagindra scripts were discovered from the territory of our country and have become the important source material for the study of history, language and culture.

The runic script sources differ greatly in their number, type and subject from those valuable literary monuments.

The study of Mongolian runic inscriptions began in 1889 when a research team from the Eastern Siberian Branch of the Russian Geographical Institute led by N.M.Yadrintsev (1842-1894) discovered the major runic monuments in the Orkhon Valley and announced them to the world. Following this discovery and announcement, a research group led by A. Heikel (Axel Olai Heikel, 1851-1924) of the Finno-Ugrian Society Association in 1890, and a special research group led by Wilhelm Radloff (1837-1918) of the Russian Academy of Sciences in 1891 came and collected the source material for the unexplained inscriptions, and a large number of research has been done around the world.

On 15 December 1894, the great Danish linguist V.Thomsen announced that the unexplained inscriptions were written with 38-letter phonetic script.

W.Radloff was the first to read the full text of a monuments and put it into a scientific circulation, such as Költigin, Bilge Khagan etc., a classic monument of Mongolian runic inscriptions, based on the original materials collected in Mongolia in 1891 and the alphabet invented by V.Thomsen.

болон В.Томсены гаргасан цагаан толгойд тулгуурлан Монголын руни бичгийн сонгодог дурсгал болох Көлтигин, Билгэ хаан зэрэг томоохон гэрэлт хөшөөний бичээсийг анх удаа бүрэн хэмжээгээр тайлан уншиж шинжлэх ухааны эргэлтэд оруулжээ.

Тэр цаг үеэс Монголын руни бичгийн сонгодог болон бага бичгийн дурсгалуудын судалгааны түүх эхэлсэн байна.

Монголын руни бичгийн судлалын түүхэн үечлэлийг *Монголын руни буюу Орхон хийгээд Енисейн бичиг судлалын нэгдүгээр үе (1889-1910–аад он), Монголын руни бичгийн судлалын хоёрдугаар үе (1930-1980-аад оны сүүл), Монголын руни бичгийн орчин үеийн судалгаа (1990-ээд оноос хойш)* гэж ангилах (Баттулга Ц. 2005:6) ба бага бичгийн дурсгалын судалгааны хүрээнд доорх байдлаар хураангуйлж дурдав.

1894-1895 он. В.Радловын "Атлас" хэмээн алдаршсан бүтээлд Көлтигин, Билгэ хаан, Туньюкук, Онги, Хар балгасын зэрэг Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудаас гадна Хойд Тамир (Тайхир чулуу)-ийн 10 бичээс, Их Асгат (Хөл Асгат) руни бичээс зэрэг бага дурсгалууд багтсан байна.

1936, 1938 он. Х.Н. Оркун "Эртний Түрэг бичээсүүд" хэмээх номын I ботид Көлтигин, Билгэ хаан, Туньюкук, Онги, Их Хөшөөт (Көличур), Шинэ ус (Моюнчур)-ын гэрэлт хөшөө, Сүүжийн даваан бичээсийг, II ботид Хар балгас I гэрэлт хөшөөний бичээснээс гадна Хойд Тамир (Тайхир чулуу)-ийн 10 бичээс, Их Асгат, Гурвалжин уулын бичээс, Улаанбаатар (Өргөөгийн) шавар ваар дээрх бичээс (Налайхын бичээс), Нэгэн хүн чулуу (Чойрын хүн чулуу) дээрх бичээс зэрэг бага дурсгалуудын уншлага, судалгааг танилцуулжээ.

1959 он. С.Е.Малов бүтээлдээ Онги, Могилян (Билгэ хаан), Моюнчурын гэрэлт хөшөөний бичээсийн хамт "Мелкие памятник (Бага бичээсүүд)" гарчигтайгаар Их Асгат I, II, Хойд Тамир (Тайхир) чулууны 10 бичээсийг дурджээ.

1968 он. Б.Ринчен "Монгол нутаг дахь хадны бичээс, гэрэлт хөшөөний зүйл" номын удиртгалд Н.Сэр-Оджав гуай *"БНМАУ-д түрэг бичээсийн дурсгалыг судалж байгаа нь"* хэмээх тойм бичсэн нь Монгол нутаг дахь руни бичгийн судлалын тухайн үеийн судалгааны тоймыг дотоод, гадаадын эрдэмтдэд мэдээлснээрээ ихээхэн ач холбогдолтой болжээ (Rintchen B. 1968:IX–XIII). Тэрбээр

From there on, the history of the study of classical and small Mongolian runic inscriptions has begun.

The historical chronology of Mongolian runic inscription is divided into *the first period of Mongolian runic or Orkhon and Yenisei script (1889-1910), the second period of Mongolian runic script (1930-late 1980s), and the modern study of Mongolian runic script (since 1990s)* and is summarized as follows in the study of small inscriptions' monuments.

1894 and 1895. W.Radloff included classic Mongolian runic inscriptions' such as Költigin, Bilge Khagan, Tunyukuk, Ongi, Khar Balgas etc. 10 inscriptions of Khoid Tamir (Taikhar Chuluu) and Ikh Asgat (Khöl Asgat) in his "Die alttürkischen Inschiften der Mongolei" book.

1936 and 1938. H.N.Orkun introduced the readings and research of classical monuments such as Költigin, Bilge Khagan, Tunyukuk, Ongi, Ikh Khöshööt, Shine Us, Süüjiin Davaa's inscription in the first volume of "Eski Türk Yazıtları (Ancient Turkic inscriptions)" and Khar Balgas 1st inscription, 10 ink inscriptions of Khoid Tamir (Taikhir Chuluu), Ikh Asgat inscription, Gurvaljin Uul inscription, Ulaanbaatar (Urga) inscription, Nalaikh inscription and Choir inscription in the second volume.

1959. S.E.Malov included a study Ikh Asgat inscriptions abd 10 link inscriptions of Khoid Tamir (Taikhir Chuluu) under the title "Small Monuments" along with the Ongi, Bilge Khan and Moyunchur steles.

1968. An overview named "Study of Turkic Inscriptions in the People's Republic of Mongolia" written by N.Ser-Odjav which was in the introduction to the book *"Les Dessigns Pictographiques et les Inscriptions sur les Rochers et sur les Steles en Mongolie"* by B.Rinchen, was overly influential information at that time for the domestic and foreign scholars about the runic script research in Mongolia. In his article, he has summarized the discovery and study of ancient inscriptions' monuments in Mongolia by our scholars from the 1950s to the early 1960s and stated *"Our articles cover some of the research work of the last few years and will continue to publish the survey review in future publications"*.

1978. B.Rinchen made a total of 27 monuments such as "Költigin Inscription, Inscription on the socle, Bilge Khagan Inscription, Tunyukuk Inscrip-

өгүүлэлдээ Монгол нутаг дахь эртний бичгийн дурсгалыг манай эрдэмтдээс 1950-аад оноос 1960 оны эхэн үе хүртэлх хугацаанд илрүүлж судалсан байдлыг товч дүгнэн өгүүлээд *"Бидний нийтэлж буй өгүүлэлд сүүлийн жилийн зарим нэгэн судалгааны ажил орсон бөгөөд бүгдийг багтаан оруулсан гэж үзэж болохгүй нь мэдээж бөгөөд дараа хэвлэгдэх дэвтэрт судалгааны тоймыг үргэлжлүүлэн нийтлүүлэх учрыг дурдана"* (Rintchen B. 1968:X) гэжээ.

1978 он. Б.Ринчен "Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас"-д *"Культегиний хөшөөний бичээс, хөшөөний суурь чулууны бичээс, Билгэ хааны бичээс, Мэргэн Тоньюкукийн бичээс, Тоньюкукийн тахилгат сүмийн шаваасны бичээс, Моюнчүр хааны бичээс, Тариатын бичээс, Куль-чүрийн бичээс, Хангидайн хадны бичээс, Ар ханангийн бичээс, Долоодойн булшны бичээс, Завхан Тэсийн бичээс, Хөл алгатайн бичээс, Сэврэйн бичээс, Дундговь, Музейд буй гарын тэмдгийн бичээс, Өвөр дөрөлжийн бичээс, Рашаан хадны бичээс, Бургалтайн ам (Цэнхэрмандал)-ны бичээс, Улсын нийтийн номын санд буй баринтагны оосрын чулуун тээгний бичээс, Тэгшийн улаан (Тэвш) бичээс, Маанытын бичээс, Яклагар хааны (Сүүжийн) бичээс, Долоон модны бичээс (Тариат) бичээс, Хар Балгасын бичээс, Бигэрийн бичээс, Тайхир чулууны бичээс, Байшин үзүүр (Дарви)-ийн бичээс, Чойрын бичээс"* зэрэг нийтдээ 27 дурсгалын бүртгэлийг гаргаж байршлыг газрын зураг тэмдэглэжээ (Ринчен Б. 1979). Энэ нь тухайн үед илрээд байсан руни бичгийн бага дурсгалыг багтаасан харьцангуй бүрэн бүртгэл болсон байна.

1990 он. Л.Болд "БНМАУ-ын нутаг дахь руни бичгийн дурсгал" номд сонгодог томоохон дурсгалуудаас гадна руни бичгийн шинээр илэрч судлагдсан 26 руни бичгийн бага дурсгалын судалгааны тоймыг дурдсан нь (Болд Л. 1986) Монгол улсын нутаг дэвсгэрээс илрүүлсэн руни бичгийн дурсгалын тухайн үеийн бүрэн судалгаа болжээ. Уг бүтээл нь Монголын руни бичгийн дурсгалыг сонирхогч, судлагч нарын гарын авлага байв.

2005 он. Ц.Баттулга "Монголын руни бичгийн бага дурсгалууд (Тэргүүн дэвтэр)" бүтээлд Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалын тоймыг

Алтайн бүс нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Хангай, Хэнтийн бүс нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

tion, Inscription on the clay piece of Tunyukuk offering site, Moyunchur (Shine Us) Inscription, Tariat Inscription, Kölichur Inscription, Khangidai Inscription, Arkhanan Inscription, Doloodoi Inscription, Zavkhan Tes (Züriin Ovoo) Inscription, Khöl Algatai Inscription, Sevrei Inscription, the stamp inscription kept in the Dundgovi Museum, Övör Dörölj Inscription, Rashaan Khad Inscription, Burgaltain Am (Tsenkhermandal) Inscription, Tegshiin Ulaan (Tevsh) Inscription, Maanit (Ongi) Inscription, Gurvaljin Uul Inscription, Yaklagar Khagan (Süüjiin Davaa) Inscription, Doloon Mod Inscription, Khar Balgas Inscription, Biger Inscription, Taikhir Inscriptions, Baishin Üzüür (Darvi) Inscription, Choir Inscription" in the "Atlas of Ethnography and Linguistics of the Mongolian People" and marked their location on the map. It is a relatively complete record, including a small collection of runic monuments that were discovered at the time.

1990. L.Bold gave an overview of newly discovered 26 runic inscriptions along with the classical large monuments in his book "Rock Inscriptions in the Territory of the People's Republic of Mongolia" which was a complete study of runic inscriptions discovered in the territory of Mongolia at that time. The book was a guide for scholars and researchers of Mongolian runic inscriptions.

2005. In a publication titled "Small Monuments of Mongolian Runic Inscription" written by Battulga Ts., an overview of runic monuments in Mongolia was introduced in accordance with the following chapters namely,

An overview of the study of runic inscriptions in the Altai region

An overview of the study of runic inscriptions in the Khangai, Khentii regions

An overview of the study of runic inscriptions in the Steppe region

An overview of the study of runic inscriptions in the Gobi region.

Ts.Battulga has given an overview of the monuments discovered since 2005 in his papers at the 10th and 11th International Conferences of Mongolic Scholars.

Dr. B.Azzaya has discussed and published articles on the study and registration of newly discovered runic inscriptions in Mongolia.

Тал хээрийн бүс нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм

Говийн бүс нутаг дахь руни бичгийн дурсгалын судалгааны тойм гэсэн үндсэн бүлэгт хуваан танилцуулжээ (Баттулга Ц. 2005:55–109).

2005 оноос хойш илрүүлсэн дурсгалын тухайд Ц.Баттулга Олон улсын Монголч эрдэмтдийн X, XI хурлын илтгэлүүддээ тоймлон өгүүлснээс (Баттулга Ц. 2012, 2017) гадна Монгол нутгаас шинээр илрүүлсэн руни бичгийн судалгаа, бүртгэлийн талаар доктор Б.Аззаяа илтгэл, өгүүлэл хэлэлцүүлж хэвлүүлсэн байна (Azzaya Badam 2010, 2017, 2018; Gerelmaa Namsrai, Azzaya Badam, and Otgonsuren Tseden 2019; Аззаяа Б. 2008a, 2008b, 2009, 2017, 2018; Баттулга Ц. and Аззаяа Б. 2009).



Баян-Өлгий аймаг. Улаанхус сум. Бага Ойгурын бичээс
The Baga Oigur Inscriptions. Ulaankhus soum. Bayan-Ölgii aimag.

Монголын руни бичгийн дурсгалын тархац

Монгол улсын 21 аймгаас Сэлэнгэ, Дархан уул, Орхон аймгаас бусад бүх аймгийн нутгаас руни бичгийн дурсгал илэрч бүртгэгдсэн байна.

Тэдгээрээс Архангай, Говь-Алтай, Баянхонгор аймгийн нутгаас руни бичгийн дурсгал харьцангуй олон тоотой илэрсэн ажээ.

Тус каталогт багтсан Монголын руни бичгийн дурсгалыг засаг захиргааны нэгжээр үзүүлбэл:


Distribution of Runic Inscriptions in Mongolia


Runic inscriptions were found in all aimags except Selenge, Darkhan-Uul and Orkhon aimags.

Among them, a large number of runic inscriptions were found in Arkhangai, Govi-Altai and Bayankhongor aimags.

Representation of Mongolian runic inscriptions by administrative units:

Монголын руни бичгийн бага дурсгал каталогт хамруулсан бичээсийн тоо, дурсгалт газар





Монголын руни бичгийн дурсгалын ангилал

Монгол нутгаас илэрсэн, зөвхөн тус каталогт хамрагдсан руни бичгийн дурсгалыг чухам юун дээр бичиж тэмдэглэсэнд тулгуурлан доорх байдлаар ангилж байна. Үүнд:

1. Хөшөөний бичээс
2. Хадны бичээс
3. Чулуун дээрх бичээс
4. Мэлхий чулуун дээрх бичээс
5. Тахилын хавтангийн бичээс
6. Буган чулуу дээрх бичээс
7. Хүн чулууны бичээс
8. Модон эдлэл дээрх бичээс
9. Ясан эдлэл дээрх бичээс
10. Шавар вааран эдлэл дээрх бичээс
11. Металл эдлэл дээрх бичээс эдгээр болно.

Жич: "Хөшөөний бичээс"-т гэрэлт болон бусад хөшөө, зэл чулууны бичээс багтаав.

"Чулууны бичээс"-т хүн өргөж зөөж болохуйц чулуунд бичиж үлдээсэн дурсгалуудыг оруулав. Хадны бичээст багтах нэг төрөл мөн боловч нэгэнт анхны байрлалаас хөдөлгөж, хол ойр зөөсөн тул "чулууны" гэж тодорхойлж тодотгохоос өөр аргагүй. Энэ төрлийн дурсгал голдуу музейд хадгалагдаж байна. Чулууг зассан, эс зассаныг үл харгалзан энэ ангилалд оруулав.


Classification of Mongolian runic inscriptions

The runic inscriptions found in Mongolia are classified as follows based on what they are inscribed on. These include:

1. The Stele Inscription
2. The Rock Inscription
3. The Stone Inscription
4. The inscription on the Tortoise-figured Socle
5. The Inscription on the Slab
6. The Inscription on the Deer-Stone
7. The Inscription on the Stone Statue
8. The Inscription on the Wooden goods
9. The Inscription on the Bone goods
10. The Inscription on the Ceramics
11. The Inscription on the Metal goods

Note: The Stele Inscription includes the steles and *balbal* inscriptions.

The Stone Inscription includes monuments inscribed on portable stones. It is a type that should be included in 'rock' inscription, but since it has been moved from its original position and moved far and wide, it can only be described as a "stone". This type of monument is usually kept in museums. The stone is included in this category, regardless of whether it has been flatten or not.



Монголын руни бичгийн дурсгалын бичгийн хэлбэр төрөл

Дурсгалын хэмжээ, агуулгаар нь руни бичгийн сонгодог дурсгал, бага дурсгал гэсэн хоёр зүйлд хуваан судалж байна. Харин бичиж үйлдсэн арга, бичлэгийн тиг хэлбэрт тулгуурлан доорх дөрвөн төрөлд ангилж болно. Үүнд:

- Сийлмэл бичээс
- Цохимол бичээс
- Зураасан болон зурчмал бичээс
- Бэхэн бичээс
- Хөөмөл бичээс

Сийлмэл бичээс

Хаад ихэс, цэргийн жанжид, язгууртан нарт зориулж босгосон руни бичгийн сонгодог дурсгалуудын үсгийн тиг, бичсэн арга уг төрөлд багтаж байгаа болно.

Цохимол бичээс

Үсэг тэмдэгтийг бичихдээ хад, чулууны өнгөн хэсгийг холцруулж, гүнзгий бус цохиж үйлдсэн бичээс "Цохимол бичээс"-ийн төрөлд хамаарна. Цохимол бичээс харагдах нь тодорхой мэт боловч ихэнх тохиолдолд дардас авах боломжгүй байдаг.

Зураасан бичээс

Хурц үзүүртэй багажаар үсэг тэмдэгтийг ганц удаа, огт давхарлахгүйгээр зурж бичсэн дурсгалууд "зураа-

Types of Mongolian runic inscriptions

According to the size and content of the monument, it is divided into two types: classical monuments and small monuments. However, it can be divided into the following four categories based on the method and type of writing used. These include:

- Engraved
- Carved
- Incised
- Scratched
- Ink-drawing
- Embossed

Engraved inscription


It is one of the classical runic inscriptions erected for kings, generals and nobles.

Carved inscription

It's a type of inscription made by gouging the surface of rock or stone and hitting them shallow. The inscription appears clear, but it is impossible to obtain a rubbing in most cases.

Incised inscription

Monuments that have been drawn with a sharp instrument once or without duplication are classified as "*incised inscriptions*". A single, "capillary" fine, dense and invisible if not carefully observed.



сан бичээс"-ийн төрөлд багтана. Ганц удаа зурсан *"хялгасан мэт"* нарийн, нягт сайн эс ажиглаваас харагдахгүй, олдохгүй байх онцлогтой.

Зурчмал бичээс

Хурц үзүүртэй багажаар зурж бичихдээ олон удаа зурж, зурчиж тодруулсан, гүнзгийлж сийлсэн бичээс *"Зурчмал бичээс"*-ийн төрөлд багтана.

Бэхэн бичээс

Архангай аймгийн Их Тамир сумын нутаг, Хойд Тамир голын хөвөөнд орших Тайхир чулууны бичээс *"Бэхэн бичээс"*-ийн төрөлд хамаарна.

Тайхир чулуунд хар, улаан бэхээр бичсэн 34 орчим руни бичээс байх бөгөөд одоогоор бэхээр бичсэн руни бичгийн томоохон цогц, цор ганц дурсгалд зүй ёсоор тооцогдож байна.


Эртний нүүдэлчдийн бэх, бэхийн соёл, бэхэн бичгийн уламжлал лавтай Түрэг, Уйгурын үед нэгэнтээ тогтож хэвшсэн байсныг Тайхирын бэхэн бичээс гэрчилж байна.

Хөөмөл бичээс

Металл эдлэл дээрх бичээсийг төвийлгэн товойлгох аргаар бичсэн байх бөгөөд тэдгээр бичээсийг үйлдсэн аргаар нь "Хөөмөл бичээс"-ийн төрөлд хамруулав.

Тэмдэглэх нь,

Алс, аглагт орших, цөөн мөрөөс бүтэх, ихэвчлэн ганц хоёр мөр, үсэг тэмдэгтүүд нь тодорхой бус, олж судлахад ч бэрхтэйгээс гад-



Scratched inscription

Monuments that have been drawn, scribbled, engraved many times with a sharp instrument are classified as *"Scratched inscription"*.

Ink-drawing inscription

The Taikhir Chuluu inscription on the bank of the Khoid Tamir River in Ikh Tamir soum of Arkhangai aimag belongs to the *"Ink-drawing Inscription"* category.

There are about 34 runic inscriptions in black and red ink on the curved stone, which is currently considered to be the only large collection of runic inscriptions in ink.

The Taikhir Chuluu inscriptions denotes that the ancient nomadic ink, ink culture, and ink inscribing tradition were established during the Turkic and Uighur periods.

Embossed inscription

The inscriptions on the metal goods are usually embossed, and these inscriptions classified as "*Embossed inscriptions*" by the method of their writing type.


на мөнгө санхүү, нөр хичээнгүй хөдөлмөр, их цагаа хугацаа шаардах тул бага бичгийн дурсгалуудыг тухайлж судалсан эрдэмтэд тун цөөн ажээ. Тиймээс ихэвчлэн Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудын орчуулга, хэлзүйн онцлог, түүхэн үйл явдлыг тодруулсан судалгаа түлхүү хийсээр ирсэн байна. Монголын төдийгүй ер руни бичгийн гарал, хөгжлийн зүй тогтлыг системтэй судлахад руни бичгийн бага дурсгалууд чухал ач холбогдолтой сурвалж, эх хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй. Тухайлбал, сонгодог дурсгалуудад тохиолдохгүй үсэг тэмдэгт, хэлзүйн өвөрмөц хэв шинж, үгийн утга хэрэглээг бага бичгийн дурсгалуудаас үзэж болно. Гагцхүү сургаар дам судлах бус, өөрийн нүдээр үзэж үсэг тэмдэгтийг зөв тогтоох нь уг дурсгалыг уншиж тайлахаас ч илүү ач холбогдолтойг тэмдэглэе.

Сүүлийн хорь гаруй жилийн турш удаа дараа нягталж цуглуулсан эх хэрэглэгдэхүүн, судалсан нөр их судалгааны үр дүнд тулгуурлаж үсэг тэмдэгт бүрийг нягтлан харьцангуй үнэн зөв, баттай тогтоосон дурсгалуудыг багтаасанд энэхүү эрдэм шинжилгээний катологийн үнэ, ач холбогдол оршино.

NOTES

There are very few scholars and researchers who have studied the small inscriptions in detail, as they are located in the wilderness, composed of few lines mainly one or two lines, as well as the letters are not clear and it is difficult to find them and it requires financing, hard work and time. Therefore, most of the research has been done on the translation of classical monuments of Mongolian runic inscriptions, their linguistic features, and historical events. Undoubtedly, small monuments of runic script are an important source and source material for the systematic study of the origin and development of not only Mongolian but also runic script. In other words, the use of letters, idioms, and word meanings that do not occur in classical monuments can be seen in the small monuments. It should be noted that watching by our own eyes and defining the characters and signs are more significant than simply reading the monuments.

The value and significance of this research catalog lies in the fact that it contains relatively accurate and well-established artifacts that have been carefully and accurately identified for each letter and symbol based on the original materials collected over the past two decades and the results of extensive research.



Өвөрхангай аймаг. Баруун Баян-Улаан сум. Таацын голын баруун эрэг. Хутаг уул.
Khutag Mountain. West shore of the Taats River. Baruunbayan-Ulaan soum. Övörkhangai aimag.



Баян Цагааны хөндий, Их Тамир сум, Архангай аймаг
Bayan Tsagaan Khöndii, Ikh Tamir soum, Arkhangai aimag

I

АРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛ

THE RUNIC INSCRIPTIONS IN ARKHANGAI AIMAG



© Ts. Battulga

Архангай аймгийн нутаг дэвсгэр Зүүн Түрэг хийгээд Уйгурын хаант улсын төр төвлөж, орд өргөөгөө байгуулж байсан стратегийн чухал газар нутаг юм. Тиймээс ч тус аймгийн нутаг дэвсгэрээс тухайн үед холбогдох түүх археологийн олон арван гайхамшигт дурсгалууд илрүүлснээс эртний бичгийн 68 орчим (давхардсан тоогоор) дурсгал бүртгэгдсэн байна.

Бид Архангай аймгийн нутгаас илрүүлсэн Түрэг, Уйгурын үед холбогдох бичгийн дурсгалд руни бичгээс гадна согд, брахми, уйгур бичгээрх дурсгалуудыг хамруулсан болно.

Тэдгээр дурсгалуудыг дурдвал:

Түрэгийн I хаант улсын үед холбогдох согд, брахми бичигт гэрэлт хөшөө-1

Түрэгийн үед холбогдох руни бичигт гэрэлт хөшөө - 2

Уйгурын үед холбогдох руни бичигт гэрэлт хөшөө - 3

Бэхэн бичээс- 34

Уйгур бичгээр бичсэн бэхэн бичээс- 2

Зэл чулууны бичээс-1

Мэлхий чулууны бичээс-2

Хадны бичээс-1

Тахилын хавтан дээрх бичээс- 2

Шавар ваар дээрх бичээс- 2

Ясан дээрх бичээс- 2 тус тус буй ажээ.

Архангай аймгийн нутаг дахь Түрэг, Уйгурын руни бичгийн дурсгал

1. Ажираг, Туулантын бичээс
2. Бага Хайрханы бичээс (I-II)
3. Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээс
4. Билгэ хааны балбалын бичээс
5. Их Хануй нуурын бичээс
6. Көлтигиний гэрэлт хөшөөний бичээс
7. Көлтигиний мэлхий чулууны бичээс
8. Моюнчур (Могойн шинэ усны)-ын гэрэлт хөшөөний бичээс
9. Нумын ясан наалт дээрх бичээс

The territory of the Arkhangai aimag is the main political and strategic region where the Eastern Turkic and Uighur Khaganates were concentrated. Therefore, there are many historical and archaeological monuments dated back to these periods that were found in this aimag. About 68 of them are ancient inscriptions.

In addition to the Turkic and Uighur period monuments discovered in Arkhangai aimag, we have included runic scripts in Sogdian, Brahmi and Uighur. These monuments include:

The monument of I. Turkic Khaganate with Sogdian and Brahmi inscription – 1

The monument of Turkic Period with runic inscription -2

The monument of Uighur Period with runic inscription -3

Ink-drawing runic inscription – 34+

Ink-drawing uighur inscription – 2

Runic inscription on the *Balbal* – 1

Runic inscription on the tortoise-figured socle – 2

Runic inscription on the rock – 1

Runic inscription on the slab – 2

Runic inscription on the ceramic – 2

Runic inscription on the bone – 1

The Runic Inscriptions related to Turkic and Uighur Period in Arkhangai Aimag

1. The Ajirag and Tuulant Inscription
2. The Baga Khairkhan Inscriptions
3. The Bilge Khagan Stele
4. The Inscription on the *balbal* of Bilge Khagan Memorial Complex
5. The Ikh Khanui Nuur Inscription
6. The Költigin Stele
7. The Inscription on the Tortoise-figured Socle of the Költigin Monument
8. The Moyunchur (Mogoin Shine Us) Stele
9. The Inscription on the Bone Plate for Reinforcing Bow

10. Тайхир чулуу (Хойд Тамир)-ны бичээс (34)
11. Тариатын гэрэлт хөшөөний бичээс
12. Мэлхий чулуун дээрх бичээс
13. Тоосгон дээрх бичээс
14. Хар балгасын I гэрэлт хөшөө
15. Хар балгасын II бичээс
16. Хиргисийн хоолойн дээврийн нөмрөг ваар дээрх бичээс
17. Чөдрийн ясан чагт дээрх бичээс

Бусад бичээс:

18. Бугатын согд, брахми бичээст гэрэлт хөшөө
19. Бичигт Хангайн уйгур бичээс
20. Улиастайн дэнжийн уйгур бичээс

10. The Taikhir Chuluu (Khoid Tamir) Inscriptions
11. The Tariat Stele
12. The Inscription on the Tortoise-figured Socle of the Tariat Monument
13. The Inscription on the Clay Brick
14. The Khar Balgas Stele – I
15. The Khar Balgas Stele – II
16. The Inscription on the Roof Tile found in Khirgisiin Khooloi
17. The Inscription on the Bone Toggle of a Hobble

Others:

18. The Bugat Stele with Sogdian and Brahmi Inscriptions
19. Uighur inscription of Bichigt Khangai
20. Uighur inscription of Uliastain Denj



Баян Цагааны хөндий, Бага Хайрхан уул
Bayan Tsagaan Khöndii, Baga Khairkhan Mountain

Ажираг, Тууланын бичээс / The Ajirag and Tuulant Inscription

Байршил / Location	Архангай аймаг. Цэцэрлэг сум. Ажирагийн гол, Туулант голын бэлчир. At the confluence of the Ajirag and Tuulant River. Tsetserleg soum. Arkhangai aimag.
Илрүүлсэн: / Year of discovery and discovered researcher	2012. Ц.Баттулга, А.Пүрэвжанцан, Б.Аззаяа 2012. Battulga Tsend, Pürevjantsan Agvaan, Azzaya Badam
Хадгалагдаж буй газар, байгууллага / Place or organization where the monument is being kept	Ажирагийн гол, Туулант голын бэлчир. At the confluence of the Ajirag and Tuulant Rivers.
Төрөл / Type	Тахилын хавтан дээрх бичээс (Саарал боржин чулуу) Inscription on slab (Gray granite)
Уншиж судалсан / Decoded by	2012. Ц.Баттулга, Б.Аззаяа 2012. Battulga Tsend, Azzaya Badam
Мөрийн тоо / Number of rows	1
Үсгийн өндөр / Height of character	3-5 см / 3-5 cm
Үсэг тэмдэгтийн тоо / Number of characters	~ 7+
Эхийн сийрүүлгэ / Original text	... 𐰾𐰃𐰇𐰚[𐰴]𐰉𐰴𐰍
Үсгийн галиг / Transliteration	l n č [ü] mTG ...
Үгийн галиг / Transcription	ilin äčüm atïγ ...
Орчуулга / Translation	улс [төр]-ийн эцэг минь нэрийг My Ancestor of the State, name
Он цаг / Dating	Түрэгийн үе / Turkic Period

References: Баттулга Ц., Пүрэвжанцан А., & Аззаяа Б. (2012). Ажираг, Туулант голын бэлчирийн тахилын онгон. Оюуны хэлхээ, Боть I (08), 103–105.






Бага Хайрханы бичээс / The Baga Khairkhan Inscriptions

Бага Хайрханы I бичээс / The Baga Khairkhan Inscription – I

Байршил / Location	Архангай аймаг. Их Тамир сум. Баянцагааны хөндий. Бага Хайрхан уул. Baga Khairkhan Mountain. Bayantsagaan Valley. Ikh Tamir soum. Arkhangai aimag.
Илрүүлсэн: / Year of discovery and discovered researcher	2009. C Salicis, Y. Mollad нар 2009. C Salicis, Y. Mollad et al.
Хадгалагдаж буй газар, байгууллага / Place or organization where the monument is being kept	Баянцагааны хөндий. Бага Хайрхан уул. Baga Khairkhan Mountain. Bayantsagaan Valley.
Төрөл / Type	Хадны бичээс / Inscription on rock
Уншиж судалсан / Decoded by	2010. Р.Мөнхтулга / 2010. Mönkhtulga Rinchinkhorol
Мөрийн тоо / Number of rows	4
Үсгийн өндөр / Height of character	1.6~1.9 см / 1.6~1.9 cm
Үсэг тэмдэгтийн тоо / Number of characters	26
Эхийн сийрүүлгэ / Original text	I. 𐰺𐰴𐰞𐰆𐰣 II. 𐰋𐰇𐰃𐰍𐰼𐰆 III. 𐰺𐰆𐰍𐰃𐰋𐰼 IV.
Үсгийн галиг / Transliteration	I. ütknda II. tŋri QGN III. ylmsi bn a IV. WLRmz
Үгийн галиг / Transcription	I. ötükändä II. täŋri qaγan III. yälmäsi äbin a IV. olurmaz
Орчуулга / Translation	I. Өтүкэнд II. Тэнгэр хааны III. алгинч нь огт IV. суухгүй The reconnoitering patrol of Tengri Khagan will not dwell in the Ötüken.
Он цаг / Dating	742

References: (Munkhtulga R., 2010, pp. 1–3; Salicis C. & Mollad Y., 2009, pp. 35–47; Мөнхтулга Р., 2010, pp. 1–8, 2018, pp. 119–127).






Бага Хайрханы бичээс / The Baga Khairkhan Inscriptions

Бага Хайрханы II бичээс / The Baga Khairkhan Inscription – II

Байршил / Location	Архангай аймаг. Их Тамир сум. Баянцагааны хөндий. Бага Хайрхан уул. Baga Khairkhan Mountain. Bayantsagaan Valley. Ikh Tamir soum. Arkhangai aimag.
Илрүүлсэн: / Year of discovery and discovered researcher	2010. Б.Арьяажав, Р.Мөнхтулга 2010. Ariyajav Batchuluun, Mönkhtulga Rinchinkhorol
Хадгалагдаж буй газар, байгууллага / Place or organization where the monument is being kept	Баянцагааны хөндий. Бага Хайрхан уул. Baga Khairkhan Mountain. Bayantsagaan Valley.
Төрөл / Type	Хадны бичээс / Inscription on rock
Уншиж судалсан / Decoded by	2010. Р.Мөнхтулга / 2010. Mönkhtulga Rinchinkhorol
Мөрийн тоо / Number of rows	1
Үсгийн өндөр / Height of character	1.2~2.2 см / 1.2~2.2 cm
Үсэг тэмдэгтийн тоо / Number of characters	21
Эхийн сийрүүлгэ / Original text	𐰇𐰾𐰃𐰍𐰇𐰃𐰋𐰇𐰃𐰾𐰃𐰍𐰾𐰇
Үсгийн галиг / Transliteration	QmG BWDNQa li tŋri QGN rms
Үгийн галиг / Transcription	qamaγ bodunqa äli täŋri qaγan ärmis
Орчуулга / Translation	Хамаг иргэнд төр нь Тэнгэр хаан байжээ. For all the people, Tengri Khagan was the state.
Он цаг / Dating	742

References: *(Munkhtulga R. 2010:1–3; Salicis C. and Mollad Y. 2009:35–47; Мөнхтулга Р. 2010:1–8, 2018e:119–27).* *References: (Munkhtulga R. 2010:1–3; Salicis C. and Mollad Y. 2009:35–47; Мөнхтулга Р. 2010:1–8, 2018e:119–27).*





Бага Хайрхан уул
Baga Khairkhan Mountain



Билгэ хааны тахилын онгоны зэл (балбал) чулууны бичээс


The Inscription on the Balbal of the Bilge Khagan Memorial Complex

Байршил / Location	Архангай аймаг. Хашаат сум. Хөшөө Цайдам. Khöshöö Tsaidam. Khashaat soum. Arkhangai aimag.
